



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/148

Хэрлэн сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны “Эрх шилжүүлэх тухай” 267, 2023 оны “Жагсаалт батлах тухай” 32 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2023 оны 02 сарын 15-ны “Төсөл арга хэмжээний гэрээ байгуулах болон худалдан авах ажиллагаа зохион байгуулах тухай” А/98 дугаар захирамжаар 5 багц болгон задалсан IX.1.131 хуулийн дугаартай “Сумдын усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, инженерийн шугам сүлжээ (Хэнтий, Баян-Адарга, Баян-Овоо, Баянхутаг, Дадал, Дэлгэрхаан, Мөрөн, Норовлин, Цэнхэрмандал сум, Батноров сум, Бэрх тосгон)” төсөл, арга хэмжээний багц-5 болох “Дэлгэрхаан сумын гадна ус хангамжийн ажил”-ыг хэрэгжүүлэх эрхийг Дэлгэрхаан сумын Засаг даргад шилжүүлсүгэй.

2. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журам, цахим системийн худалдан авах төлөвлөгөөний хугацааны дагуу шуурхай зохион байгуулах, 2023 оны 05 дугаар сарын 01-нд багтаан шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж худалдан авах ажиллагааг бүрэн дуусгах, барилга угсралт, их засварын ажлын захиалагчийн техник хяналтыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай гэрээ байгуулан хэрэгжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Дэлгэрхаан сумын Засаг дарга Э.Төгөлдөрт даалгасугай.

3. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Г.Лхагвахатан), барилга угсралт, их засварын ажлын

2.

захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Сүнгээ) нарт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023 оны
 03 дугаар сарын 25 -ны өдрийн
 01/118 дугаар захирамжийн хавсралт

Д/д	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нэр	Хугацаа		Төсөвт өртөг	2023 онд санхүүжих	Эрх шилжүүлсэн ТЕЗ
		Эхлэх	Дуусах			
1	Сумдын усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, инженерийн шугам сүлжээ (Хэнтий, Баян-Адарга, Баян-Овоо, Баянхутаг, Дадал, Дэлгэрхаан, Мөрөн, Норовлин, Цэнхэрмандал сум, Батноров сум, Бэрх тосгон) Багц-5: Дэлгэрхаан сумын гадна ус хангамжийн ажил	2022	2023	188,586,947.0	188,586,947.0	Дэлгэрхаан сумын Засаг дарга